



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 03 өдөр

Дугаар A/155

Булган сум

“Брайл цонх” төслийг хэрэгжүүлэхэд  
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, 42.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” A/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хараагүй иргэдийн нийгмийн харилцаанд оролцоход нь дэмжлэг үзүүлэх зорилготой Монголын хараагүйчүүдийн Үндэсний холбооноос тус аймагт “Брайл цонх” төслийг 2026 оны 03 дугаар сарын 03 өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Н.Батжаргал)-д үүрэг болгосугай.

2.Шаардагдах хөрөнгө 1,864,500 (нэг сая найман зуун жаран дөрвөн мянга таван зуу) төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010203

Аймгийн Засаг даргын 2026. оны  
03 дугаар сарын 03-ны/ний өдрийн  
А/ISS... дугаар захирамжийн хавсралт

“БРАЙЛ ҮСГИЙН” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД  
ШААРДАГДАХ ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр	Тоо (хоног, ширхэг)	Хоногийн зардал (төгрөгөөр)	Нийт зардал (төгрөгөөр)
1	2	3	4	5
1	Брайл үсгийн багш байрлах буудлын зардал (Булган буудал)	14	80,000	1,120,000
2	МХҮХ-ны менежер байрлах буудлын зардал (Булган буудал)	1	100,000	100,000
3	Харааны бэрхшээлтэй иргэдийн сургалтын цайны зардал (15 суралцагч)	14	36,000	504,000
4	Төрийн албан хаагч, нийгмийн ажилчдын сургалтын цайны зардал	3	36,000	108,000
5	Нэг удаагийн аяга (50 ширхэгтэй)	5	6,500	32,500
<b>Нийт зардал</b>				<b>1,864,500</b>

--o00o--